

Инвест Монголиа Токио хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт




Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, Япон Улсын Ерөнхий сайд Шинзо Абэ болон БНХАУ, ОХУ-ын төрийн тэргүүн, БНСУ-ын Ерөнхий сайд нарын хамт ОХУ-ын Владивосток хотод 2018 оны 9-р сард болсон Дорнын эдийн засгийн чуулганы үеэр.

~ Монголын улс төр, эдийн засгийн байдал, хөрөнгө оруулалтын орчин, бизнесийн боломжууд ~

Монгол улсын Засгийн газар 2030 он гэхэд нэг хүнд ногдох ДНБ-ийг 17,500 ам.доллар болгож эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх бодлого баримтлах болно гэдгээ зарлав. Одоогоор нэг хүнд ногдох ДНБ 3800 ам.доллартай тэнцэж байна. Түүнчлэн 2030 онд Монголын хүн ам одоогийн түвшнээс ойролцоогоор 20% -иар нэмэгдэж 3.5 сая болох төлөвтэй. Улмаар ДНБ нь өнөөгийн түвшин болох 10 тэрбум ам.доллараас 6 дахин их буюу 60 тэрбум ам.доллар хүртэл өсөх болно.

Энэ нь дэлхийн хэмжээнд урьд хожид байгаагүй хурдацтай өсөлтийн жишээ болох тул ийм түвшний өндөр эдийн засгийн өсөлт боломжтой юу? Ийм зэргийн өндөр өсөлт үзүүлнэ гэвэл ямар салбар илүү ирээдүйтэй вэ? Түүнчлэн Япон улстай тогтоосон холбоо харилцаан дээр үндэслэж үзвэл Японы хөрөнгө оруулагчид үр ашиг хүртэх ямар салбар байгаа талаар судалж үзэж байна.

Энэхүү чуулга уулзалтад Монголын Засгийн газрын албан тушаалтнууд, бизнесийн байгууллагын захирлууд, олон улсын хөгжлийн санхүүгийн байгууллагуудыг урьж оролцуулан, Монголын улс төр, эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын орчин, бизнесийн боломж зэрэг асуудлуудыг хэлэлцэнэ. Үүнээс гадна, чуулга уулзалтын хажуугаар “Бизнесийн уулзалт” болон Нэтворкин дринк зохион байгуулагдах бөгөөд та бүхнийг тус арга хэмжээнд идэвхтэй оролцохыг урьж байна.



Огноо: 2018 оны 11-р сарын 19-ний өдөр (Даваа гараг)

9:00~18:00 (Бүртгэл эхлэх цаг 8:30)

Хурал болох газар ЖАЙКА Олон Улсын Плаза 2 дугаар давхар Олон улсын чуулганы танхим

Хаяг: Токио хот, Шинжюкү дүүрэг (ЖАЙКА Ичигаяа-д)

УТАС: 03-3269-2911 (Чуулган болох газрын талаарх ерөнхий асуулт тайлбар)

Хурал болох газар руу очих метроны гарц

- **JR:** Чүо шугам · Собү шугам.
Ичигаяа буудлаас 10 минут алхана
- **Токио метро:** Юуракучо шугам, Шинжюкү шугам
Ичигаяа өртөө А1 болон 4 дэх гарцнаас 10 минут алхана
- **Токио метро:** Юуракучо шугам, Нанбоку шугам
Ичигаяа өртөөний 6-р гарцнаас 8 минут алхана

Зохион байгуулагч: Фронтьер Жапан

Оролцогчдын тоо: +200 хүн

Бүртгэлийн хураамж: Үнэгүй

※ Чуулганы бүртгэлийн цэг дээр өгөх зорилгоор нэрийн хуудас нэг ширхэгийг авчирна уу.

Чуулганы урьдчилсан хөтөлбөр

Цаг	Үндсэн хөтөлбөрийн агуулга	Үндсэн илтгэгч
8 : 30	Бүртгэл эхлэх	
9 : 00	Хурал нээж үг хэлэх	Фронтинер Жапан
9 : 10	Хүндэт зочдын мэндчилгээ	Япон, Монголын засгийн газрын албан тушаалтан
9 : 30	Япон-Монголын улс төр, эдийн засгийн хэтийн төлөв	Япон, Монголын засгийн газрын албан тушаалтан
10 : 00	Япон, Монголын дэд бүтэц зэрэг салбар дахь хамтын ажиллагаа, харилцаа холбоо	Монгол Улсын Үндэсний Хөгжлийн газрын дарга (урилгаар)
10 : 20	Монголын эдийн засгийн хэтийн төлөв	Эдийн засагчид
11 : 10	Японы техник технологи, ноу-хау зэргийг Монгол Улсад нэвтрүүлэх, Японы зүгээс хийх хөрөнгө оруулалт	Хувийн компаниуд
11 : 40	Монгол Улсын эрдэс баялгийн экспорт, Эрдэнэс Таван Толгойн хувьцааг олон улсад гаргах, Японы хөрөнгө оруулагчдын оруулах хувь нэмэр	Эрдэс баялгийн салбарын мэргэжилтнүүд
12 : 20	Монгол Улсад Японы нийтийн хоолны салбар нэвтрүүлэх боломжийн талаар	
13 : 00	Өдрийн хоол	
14 : 00	Монголд бизнес эрхлэх боломжийн талаар	Монгол улсын талаарх мэдлэгтэй, мэргэшсэн мэргэжилтнүүд
14 : 50	Шинэ нисэх онгоцны буудлын менежментийг богино хугацаанд эхлүүлэх, Монгол улсын аялал жуулчлалын салбарын ирээдүйн хөгжил	
15 : 10	Санхүүгийн салбар болон менежментийн шинэчлэл, хөрөнгө оруулалтын боломжийн талаар	Арилжааны банкууд, Банк бус санхүүгийн байгууллагууд
15 : 40	Япон улсад монголчуудын эрхэлж буй бизнесийн үйл ажиллагааны талаар	
16 : 10	Байгаль орчны асуудлууд болон дэд бүтцийн хөгжилд Японы компаниудын оролцох боломж	
16 : 40	Монголын нягтлан бодох бүртгэлийн болон эрх зүйн тогтолцооны өнөөгийн байдал	Аудит болон хуулийн компаниуд
17 : 10	Хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулах боломжууд	
17 : 50	Хурлын хаалтын үг	
18 : 00	Нэтворкин дринк	Чуулганы гадна танхимд

Жич :

- ① Чуулга уулзалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах боломжтой.
- ② Чуулга уулзалтыг Монгол, Япон хэлээр шууд орчуулан хүргэх болно
- ③ Чуулганы үеэр болох “Бизнесийн уулзалт” дээр сурталчилгааны ширээ авч компани танилцуулах хүсэлтэй байгууллагууд доорх цахим шуудангаар холбоо барина уу.
- ④ Бид мэдээлэл солилцох уулзалтын үеэр япон болон англи хэлээр ярьдаг хэд хэдэн орчуулагчийг ажиллуулах төлөвлөгөөтэй байгаа.
- ⑤ Чуулга уулзалтад оролцох хүсэлтэй хүмүүс [ЭНД](#) дарж онлайнаар бүртгүүлнэ үү.
※Таны ирүүлсэн хувийн мэдээллийг зөвхөн энэхүү чуулга уулзалттай холбоотой зорилгоор ашиглах бөгөөд бусад зорилгоор ашиглахгүй болно.
- ⑥ 2017 оны 11-р сарын 24-ний өдөр зохион байгуулагдсан Инвест Монголиа Токио 2017 чуулганы тайланг [ЭНД](#) дарж үзнэ үү.

Зохион байгуулагч: Фронтинер жапан болон Фронтинер ҮЦК (<http://www.frontier.mn/>)
Хөрөнгө оруулалтын чуулга уулзалт хариуцсан алба
Цахим шуудан: conference@frontier.mn Утас: (+976) 7575-5161